

**НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН АЖИЛТАН, АЛБАН
ХААГЧДЫН 2018 ОНЫ 9, 10 ДУГААР САРЫН ЦАГ АШИГЛАЛТЫН ТУХАЙ
ИЛТГЭХ ХУУДАС**

2018 оны 11 дүгээр сарын 14

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2018 оны 03 дугаар албан даалгаварын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын ажилтан, албан хаагчтай хариуцлага тооцох үүднээс ур чадварын нэмэгдлийг шат дараатай бууруулах, шалтгаангүйгээр ажил тасалсан ажилтан, албан хаагчдад хөдөлмөрийн дотоод журмын дагуу хариуцлага тооцох зэрэг ажлуудыг зохин байгуулан ажиллаж байна.

Тайлант хугацаанд ээлжийн амралттай 8, өвчтэй 23, холбогдох журмын дагуу чөлөө авсан 17, 1 өдрийн ажил шалтгаангүй тасалсан 4 ажилтан, албан хаагч байсан.

Сар бүрийн эхэнд өмнөх сарын цагийн бүртгэлийн мэдээг хурууны хээг бүртгэх төхөөрөмжөөс авч, цагийн бүртгэлийн тооцоог гаргахдаа гадуур ажлын дэвтэр, чөлөөний бүртгэлийн дэвтэр, байр хариуцсан менежерүүд, удирдах албан тушаалтны тайлбаруудтай тулгалт хийсэн.

Ажилтан, албан хаагчдын ажлын хоцрогдолыг 9, 10 дугаар сараар харьцуулан гаргаж, 10 дугаар сарын байдлаар шар өнгийн сануулах хуудас 58, цэнхэр өнгийн сануулах хуудас 1, улаан өнгийн сануулах хуудас 6 ажилтан, албан хаагчдад тус тус хүргүүлэн сануулах арга хэмжээ авч ажиллалаа.

ТАНИЛЦСАН:
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Х.ЭРДЭНЭБИЛЭГ

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ч.ШИНЭЧИМЭГ

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:
ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ АЖИЛТАН

Т.ИТГЭЛ